

# ХӨРГӨХ БОДИСЫН ТАЛААРХ ШИНЭ ЖУРАМ

HCFC-22	HCFC-123	R-406A	R-408A	HCFC-141B	HCFC-134A
HFC-32	R-404A	R-407C	R-410A	R-507A	

Хэрвээ та гол төлөв худалдаанд байдаг дээрх хөргөх бодисуудыг дангаар нь эсвэл холимог хэлбэрээр импортлох эсвэл экспортлох гэж байгаа бол дараах мэдээллийг **Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд** өгнө.



Монгол улсад гидрофторт нүүрстөрөгч (**ГФН/НFCs**) болон бусад хөргөх бодисыг импортлох/экспортлох шинэ журмыг баримталж байгаа. Журам мөрдөгдөх тухайн өдрөөс эхлэн ГФН/НFCs төрлийн хөргөх бодисыг импортолохдоо **БОАЖЯ-ны Озоны үндэсний албанаас** заавал тусгай зөвшөөрөл авна.



2024 оноос эхлэн **БОАЖЯ-ны Озоны үндэсний албанаас** тусгай зөвшөөрөл олгох квотын системээр Монгол улсад хуваарилсан тоо хэмжээний хүрээнд **ГФН/НFCs** төрлийн бодисыг импортолно.



Олон улсын хэмжээнд барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн шинэчлэгдсэн кодоор бүртгэгдсэн ГФН/НFCs төрлийн бодисуудыг төрөлжүүлэн ангилдаг. Импортлох үед хөргөх бодисын тодорхойлолтыг хэрхэн зөв мэдүүлэх талаар гаалийн газартай холбогдох шаардлагатай.



Бүх импортлогчид **БОАЖЯ-ны Озоны үндэсний албатай** заавал холбогдож **ГФН/НFCs** болон **ГХФН/НСFCs** төрлийн хөргөх бодисыг импортлосон тайлангаа цаг тухайд нь мэдээлж байх үүрэгтэй.



**CFCs** төрлийн хөргөх бодисыг импортлох нь **хориотой**. Харин квотоор тогтоосон тоо хэмжээний хүрээнд тодорхой хэмжээтэй **ГХФН/НСFCs** төрлийн хөргөх бодисын импортыг тусгай зөвшөөрлөөр зохицуулдаг.



Лавлах:  
БОАЖЯ-ны  
Озоны үндэсний алба  
Утас: 976 11 312458  
Email: mongolia@ozone.mn

Зохицуулагдсан бодисын жагсаалт  
<https://bit.ly/2HDRtio>

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор:  
<https://bit.ly/38UACEI>

Засгийн газрын 277-р тогтоол  
<https://www.legalinfo.mn/law/details/13670>